



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/361

Ховд

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6-а, 29.2, 30.1.6, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.1, 17.1.10, Засгийн газрын 2018 оны 210 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайд Ховд аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах ажиллах гэрээний хавсралтын 1-Б-1, 3-ын ажил үйлчилгээ-1.6-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Халхын голын 1939 оны байлдааны ялалтын түүхт 80 жилийн ойг Ховд аймагт зохион байгуулах, тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагчаар:

Д.Энхболд -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Б.Ганхуяг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа

Б.Даваадорж -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ч.Багдал -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

М.Болдбаатар -Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа

П.Мөнхбат -Манхан сумын Засаг дарга

Д.Мягмарцоож -Орон нутгийн музейн захирал

Ч.Дамбадаржаа -Аймгийн ахмадын хорооны дарга

Г.Төрмөнх -“Шинэ эвлэл” орон нутгийн сэтгүүлчдийн
холбооны тэргүүн, сэтгүүлч

А.Жаргалсайхан -Зохиолч, бэлтгэл дэд хурандаа

Нарийн бичгийн бичгийн даргаар:

Б.Мөнгөнцөөж -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт,
сургалтын офицер

2. Халх голын байлдааны ялалтын түүхт 80 жилийн ойг Ховд аймагт тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах зарлын тооцоо гаргахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Мөнгөнцөөж, гишүүн Ч.Багдал нарт даалгасугай.

4. Ойг тэмдэглэн өнгөрүүлсэн тухай тайлан гаргаж холбогдох газарт 2019 оны 09 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Д.Энхболд/, нарийн бичгийн дарга /Б.Мөнгөнцөөж/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДУГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/361 дүгээр захирамжийн хавсралт

ХАЛХЫН ГОЛЫН БАЙЛДААНЫ ЯЛАЛТЫН ТҮҮХТ 80 ЖИЛИЙН ОЙГ ХОВД АЙМАГТ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Газар	Төсөв, мянган төгрөг	Хариуцан ажиллах ажлын хэсгийн гишүүн болон байгууллага	Гүйцэтгэх болон хамтран ажиллах байгууллага, албан тушаалтан
Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар						
1.	Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай аймгийн Засаг даргын захирамж болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах	05 дугаар сарын 30-ны дотор	Цэргийн штаб	-	Цэргийн штабын дарга дэд хурандаа Б.Ганхуяг	ЦШ-ОНХСО хошууч Б.Мөнгөнцоож
2.	Зохион байгуулах арга хэмжээнд зарцуулагдах хөрөнгийн тооцоо гарган батлуулж зарцуулах түүнд хяналт тавих	05 дугаар сарын 30-ны дотор	АЗДТГ		СТСХ-ийн дарга Ч.Багдал	Цэргийн штабын дарга дэд хурандаа Б.Ганхуяг
3.	Ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй зохионх байгуулах үйл ажиллагааны талаар хурал хийх. Ажлын хэсгийн гишүүдийн санал авах	06 дугаар сарын 03-ны өдөр	АЗДТГ-ын Иргэний танхимд	-	АЗДТГ-ын дарга Д.Энхболд	Ажлын хэсгийн гишүүд
4.	Ой тэмдэглэн өнгөрүүлсэн болон ой хүрээнд зохион байгуулж явуулсан арга хэмжээний тайлан гаргаж холбогдох газруудад хүргүүлэх.	10 дугаар сарын 15-ны дотор	Цэргийн штаб	-	Цэргийн штабын дарга дэд хурандаа Б.Ганхуяг	ЦШ-ОНХСО хошууч Б.Мөнгөнцоож

Хоёр. Халхын голын байлдааны ялалтын ач холбогдолыг сурталчлах, ойг тэмдэглэн өнгөрүүлэх чиглэлээр

1.	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурлага, урлаг, спортоор манлайлагч сурагчдыг баруун хилтэй танилцах аялалд оролцуулна.	06 дугаар сард	Ховд хот- Булган сум Байтаг богд		Цэргийн штаб	Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль
2.	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын төлөөллийг Ховд аймагт үйл ажиллагаа явуулж буй Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай танилцуулах үйл ажиллагааг тусгай төлөвлөгөөгөөр зохион байгуулна.	09 дүгээр сард	Жаргалант суман дахь тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд		Цэргийн штаб	БСУГ, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд
3.	Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран "Халхын голын байлдааны ялалт 80" сэдэвт лекцийг Ховд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, их сургууль коллежийн оюутнууд, төрийн албан хаагчдад уншуулна.	09 дүгээр сард	Жаргалант суманд		Цэргийн штаб	БСУГ газар болон холбогдох байгууллагууд
4.	Ховд аймгаас Халхын голын байлдаанд оролцож эрэлхэгээр тулалдаж явсан дайчдын үр хүүхдүүдийг Улаанбаатар хот болон Дорнод аймагт зохион байгуулагдах баярын үйл ажиллагаанд оролцуулах ажлыг зохион байгуулна.	08-09 дүгээр сард	Улаанбаатар хот болон Дорнод аймаг		Ажлын хэсэг, Цэргийн штаб	
5.	Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ой, энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан 2 суманд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	06 дугаар сард	Мянгад, Дөргөн сум		Цэргийн штаб	Зэвсэгт хүчний 123 дугаар анги

6.	БНМАУ-ын баатар Ц.Олзвой мэндэлсний 105 жилийн ойг төрлөх нутагт нь тэмдэглэн өнгөрүүлэх	2019 оны 06-09 дүгээр сард	Манхан суманд		Ажлын хэсэг болон Манхан сумын ЗДТГ	
7.	БНМАУ-ын баатар Ц.Олзвойн амьдрал болон эх орныхоо төлөө баатарлагаар тэмцэж явсан үйл хэргийг хойч үеийнхэнд сурталчлах зорилгоор түүхэн баримтат кино болон дуулалт жүжиг бүтээн иргэдийн хүртээл болгох	Жилдээ	Түүхэнд холбогдох газруудад		Ажлын хэсэг болон хамтрагч байгууллагууд	
8.	Дайн, байлдаан, тулгаралтад болон фронтод бэлгийн цуваа хүргэх ажилд оролцогчдод нэг удаагийн тэтгэмж олгох асуудлыг Засгийн газарт уламжилж шийдвэрлүүлэх (Засгийн газрын тогтоол, төлөвлөгөөний дагуу)	2019 оны эхний хагас жилд			Аймгийн ИТХ, ЗДТГ-ын Цэргийн штаб, Ахмадын хороо	
9.	Сибирийн цэргийн тойрогт тэмдэглэх ялалтын 80 жилийн ойн баярын арга хэмжээний хүрээнд Горно-Алтайск хотод болох эрдэм шинжилгээний бага хуралд төлөөлөгч оролцуулах	2019 оны 5 дугаар сарын 20-25	Горно-Алтайск хот		Аймгийн ЗДТГ, Цэргийн штаб, ажлын хэсэг	
10.	Халхын голын байлдааны ялалтын тухай теле хэлэлцүүлэг өрнүүлэх	2019 оны 6 сарын 15-25-ны хооронд Мөн 9 сарын 01-нд	Жаргалант суманд		Ажлын хэсэг Орон нутгийн ТВ-тэй хамтрах	
11.	ТВ –ийн нэвтрүүлэг, сонин, сайтийн нийтлэл бэлтгэж олон нийтэд хүргэх	2019 оны 9 сарын 02-ноос өмнө			Ажлын хэсэг	Орон нутгийн ХМХ-ийн байгууллагууд
12.	Дайн, байлдаан, тулгаралтад оролцсон ахмад дайчдын гавьяаг сурталчлан алдаршуулах, амьдрал	2019 оны 6 дугаар сараас			Аймгийн ИТХ, ЗДТГ, Цэргийн штаб, ажлын	

	ахуйд нь туслах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах	8 сарын 30			хэсэг	
13.	Ялалтын 80 жил яруу найргийн наадам зохион байгуулах	2019 оны 8 сар			Ажлын хэсэг, Цэргийн штаб, МЗЭ-ийн Алтай салбар, ЗХ-ний 123 дугаар анги	
14.	Ялалтын ойг тохиолдуулан дайчдын хөшөө, дурсгалд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	2019 оны 8 дугаар сард			ИТХ, ЗДТГ, Цэргийн штаб	
15.	Ялалтын ойн баярын хурал, хүндэтгэлийн тоглолтын арга хэмжээ зохион байгуулах	2019 оны 8 дугаар сард			ИТХ, ЗДТГ, Цэргийн штаб, ажлын хэсэг, ХДТ	